



Title	МИНЬХЭ МОНГОР ХЭЛНИЙ ҮГ БҮТЭЭХ ДАГАВРЫН СУДАЛГАА
Author(s)	塩谷, 茂樹
Citation	外国語教育のフロンティア. 2023, 6, p. 21-38
Version Type	VoR
URL	https://doi.org/10.18910/91026
rights	
Note	

The University of Osaka Institutional Knowledge Archive : OUKA

<https://ir.library.osaka-u.ac.jp/>

The University of Osaka

МИНЬХЭ МОНГОР ХЭЛНИЙ ҮГ БҮТЭЭХ ДАГАВРЫН СУДАЛГАА

A Study of the Derivational Suffixes in the Mangghuer Language (民和土族語の派生接尾辞の研究)

塩谷 茂樹

Abstract

The Mangghuer language belongs to the Mongolic languages and is spoken in Guanting town in the southeast of Minhe Hui and Tu Autonomous County, Qinghai province, China.

The morphological study of the Mangghuer language, especially the research of the derivational suffixes has not been fully made until now, therefore the author first classified them into five categories, that is 1. Denominal nominal suffixes (N-N), 2. Deverbal nominal suffixes (V-N), 3. Denominal verbal suffixes (N-V), 4. Deverbal verbal suffixes (V-V), 5. Departicle verbal suffixes (P-V), and then tried to describe both form and meaning of all suffixes of the language.

Moreover he made his first attempt to clarify the “succession” and “innovation” of the language from a diachronic perspective, and hopes that this paper will cast new light on the study of morphology, vocabulary, and dialectology of the Mongolic languages.

キーワード：民和土族語、派生接尾辞、継承、革新

Түлхүүр үг: Миньхэ монгол хэл, үг бүтээх дагавар, уламжлал, шинэчлэл

Эхлэл

Миньхэ монгол хэл бол Хятадын Цинхай мужийн Миньхэ хотон монгол үндэстний өөртөө засах шяний Гуантин балгасны монгорчуудын ярьдаг хэл бөгөөд монгорчууд нь түүхэндээ бичиг үсэг хэрэглэж байсангүй. Одоогоор тус хэлээр хэлэлцэгч арван мянга гаруй хүн байна гэсэн тооцоо бий.

Миньхэгийн монгорчуудын хэлний талаар Тодаева Б.Х (1973), Dpal-Idan-bkra-shis, Keith.Slater нар (1996), Jiang Genxiong (2018), Keith W.Slater (2003a,b) зэрэг судлаачийн ном бүтээл, өгүүлэл гарч, одоогийн Миньхэ монгол хэлний төлөв байдлыг зохих хэмжээгээр товчоолон дурдсан байдаг. Гэвч алинд нь ч тус хэлний үгзүй ба үгсийн сангийн талаар бараг судлаагүй гэж болох байна.

Миний бие тус өгүүлэлдээ Миньхэ монгол хэлний “үгзүй (*morphology*)”, ялангуяа “үг бүтээх дагавар (*suffix*)”-ыг онцгойлон авч үзлээ.

Миньхэ монгол хэлний үг бүтээх дагаврыг дотор нь 1. *Нэрээс нэр бүтээх дагавар* (N→N, N(ominal class): Нэр үг), 2. *Үйлээс нэр бүтээх дагавар* (V→N, V(erbial class): Үйл үг), 3. *Нэрээс үйл бүтээх дагавар* (N→V), 4. *Үйлээс үйл бүтээх дагавар* (V→V),

5. *Сул үгээс үйл бүтээх дагавар* ($P \rightarrow V$, P(article class): Сул үг) гэсэн таван бүлэгт хувааж, дагавар тус бүрийн хэлбэр, утгыг жишээгээр үзүүлж тодруулахын зэрэгцээ, ялангуяа хэлний “уламжлал” ба “шинэчлэл” гэсэн хоёр талаас Миньхэ монгол хэлий үг бүтээх дагаврыг задлан судлахыг зорилоо.

1. Нэрээс нэр бүтээх дагавар ($N \rightarrow N$)

Миньхэ монгол хэлний нэрээс нэр бүтээх гол дагавруудыг доор үзүүлэв.

1.1 -buri [-buri] (Kh.-уур/-үүр, Mo.-yur/-gür)

cf. Kh: Халхын аялгуу, Mo: Монгол бичгийн хэл

Тус дагаврыг голдуу орон зай заах нэр үгэнд залгаж, “тухайн юмны өргөн хэмжээ”-г заасан нэр үг бүтээнэ.

zhagha-buri [dzʰɑɑburi] (“дээгүүр”, Mo.degegür < *dege-)

< zhagha [dzʰɑɑ] (“дээр”, Mo.deger-e < *dege-)

duoruo-buri [duoruoɔburi] (доогуур, Mo.douyur < *dou-)

< duoruo [duoruo] (доор, Mo.dour-a < *dou-)

dongda-buri [doŋdaburi] (дундуур, Mo.dumdayur)

< dongda [doŋdaburi] (дунд, Mo.dumda)

ghada-buri [ɡadaburi] (гадуур, Mo.ɣadayur < *ɣada-)

< ghada [ɡada] (гадаа, Mo.ɣadaɣ-a < *ɣada-)

ning-buri [niŋburi] (“наагуур”, Mo.naɣayur < *naɣa-)

< ni [ni] (энэ, Mo.ene)

ting-buri [tiŋburi] (“цаагуур”, Mo.ɕayayur < *ɕaya-)

< ti [ti] (тэр, Mo.tere)

1.2 -chuer [-tʂuə] ∞ -ngchuer [-ŋtʂuə] (Kh.-нцар⁴, Mo.-nčar/-nčir)

Тус дагаврыг цөөн тооны нэр үгэнд залгаж, “тухайн хүний зан ааш, дадал зуршил бүхий” гэсэн утга санааг илэрхийлнэ.

khaber-chuer [qɑbətʂuə] (“уйланхай” (← нусгай))

< khaber [qɑbət] (1.хамар, Mo.qabar ~ qamar, 2.нус)

khuola-ngchuer [quolaŋtʂuə] (хоолонцор, Mo.qoɣulančar)

< khuoluo [quoluo] (хоолой, Mo.qoɣulai)

1.3 -da [-da] (Kh.-д, Mo.-da/-de (өгөх оршихын тийн ялгал))

Тус дагаврыг нэр үг, тухайлбал тэмдэг нэрд залгаж, тухайн утга бүхий дайвар үг үүсгэнэ. Хэлбэрийн хувьд авч үзвэл энэ нь өгөх оршихын тийн ялгалын -da нөхцөлтэй гарал нэгтэй болов уу гэж бодож байна.

Орчин цагийн монгол хэлэнд энэхүү дагавар нь зарим цөөн үгэнд л (жишээ нь: ихэд < их, машинд < маш г.м.) тохиолддог байхад Миньхэ монгол хэлэнд харин ч харьцангуй идэвхтэй хэрэглэгддэг байна.

gezai-da [gədzaida] (сайнаар, сайтар) < gezai [gədzai] (сайн, Мо.sayin)
 wudang-da [udaŋda] (удаанаар) < wudang [udaŋ] (удаан, Мо.udayān)
 zhuzhuang-da [dzudzuaŋda] (“шигүүгээр”)
 < zhuzhuang [dzudzuaŋ] (“1.зузаан, 2.өтгөн, 3.шигүү” зузаан, Мо.jūjāyān)
 khalong-da [qalɔŋda] (халуунаар)
 < khalong [qalɔŋ] (халуун, Мо.qalayūn)
 geigan-da [gəiganda] (гэгээтэйгээр) < geigan [gəigan] (гэгээн, Мо.gegen)
 khara-da [qarada] (хараар) < khara [qara] (хар, Мо.qar-a)

1.4 -di [-di] (Kh. -, Mo. -)

Тус дагаврыг голдуу хятад гаралтай үг (Ch: Хятад хэл)-энд залгаж, тухайн байдлын утга бүхий дайвар үг үүсгэнэ. Гарлын хувьд авч үзвэл энэ нь хятад үгийн -di (地)-гээс ирсэн бололтой.

yigama yigama-di [jigama jigamadi] (“нэг үмхээд” гэсэн санаа)
 < yigama [jigama] (< Ch. 一个 yige [jigə] “нэг” + ama [ama] “ам”)
 mermer-di [mə-mə-di] (“аажим аажмаар” гэсэн санаа)
 < mermer [mə-mə] (Ch. 慢慢 manman, “аажим, удаан”)
 anamana-di [anamanadi] (“цэмбийгэл” гэсэн санаа)
 < anamana [anamana] (“эмх цэгцтэй”)
 dididuoduo-di [dididuoduodi] (“сунжирсан байдалтай” гэсэн санаа)
 < dididuoduo [dididuoduo] (“сунжирч удах”)

Жич: Миньхэ монгол хэлэнд монгол төрөл хэлнээс нийтлэг уламжлагдсан өгөх оршихын тийн ялгалын -du нөхцөл байна. Жишээ нь: *mori-du biesi hu-ba* (Моринд өвс өгөв), *ana-du nukuerber-serbang* (Ээжид тусалсаар байна) гэхчилэн түгээмэл хэрэглэгдэнэ. Бас тус хэлэнд “connective case” -di (接点格 / “нийлэхийн тийн ялгал” гэж шинээр томъёолон хойшид ийнхүү нэрлэе) гэж өвөрмөц тийн ялгал ч байгаа бөгөөд энэ нь *diere* [diərə] (дээр) гэсэн үгнээс үүссэн бололтой. Жишээ нь: *wula-di gher-* (ууланд гар-), *shidian-di enta-* (арван цагт унта-) гэх мэтээр хэрэглэгдэнэ. Дүгнэж хэлэхэд дээрх 1.4-т дурдсан -di дагавар нь энэхүү “нийлэхийн тийн ялгал”-ын -di нөхцөлтэй гарлын хувьд огт холбоогүй гэж үзэж байна.

1.5 -du [-du] (Kh.-д, Mo.-da/-de ∞ -du/-dū)

Тус дагаврыг нэр үгэнд залгаж, “тухайн юмны газар орон, юмны байршил”-ыг заана.
 ning-du [niŋdu] (энд, Мо.ende < *e-n-de) < ni [ni] (энэ, Мо.ene < *e-)
 ting-du [tiŋdu] (тэнд, Мо.tende < *te-n-de) < ti [ti] (тэр, Мо.tere < *te-)
 khergha-du [qə-ɣadu] (хажууд, Мо.qajayuda)
 < khergha [qə-ɣa] (хажуу, Мо.qajayu)
 zhuerge-du [dzue-ɣədu] (“сэтгэлд, зүрхэнд”, Мо.jirüken-dü)
 < zhuerge [dzue-ɣə] (зүрх, Мо.jirüke)
 cuduoruo-du [tsuduoruo] (“дотор, дотогш”, Мо.dotur-a)
 < cuduoruo [tsuduoruo] (дотор, Мо.dotur-a)

ghada-du [ɣadadu] (“гадаа, гадна”, Мо.γadaγ-a)

< ghada [ɣada] (гадаа, Мо.γadaγ-a)

1.6 -ge [-gə] (Kh.-x, Mo.-ki)

Тус дагаврыг нэрийн харьяалахын тийн ялгал *-ni* нөхцөлийн дараа залгаж, “тухайн хүний эзэмшиж байгаа юм” гэсэн утгыг илтгэнэ.

bater-ni-ge [batə-nigə] (Баатарынх) < bater-ni [batə-ni] (Баатарын)

< bater [batə] (Баатар (Миньхэ монгол эрэгтэй хүний нэр))

muni-ge [munigə] (минийх, Мо.minüki) < muni [muni] (миний, Мо.minü)

qini-ge [tɕinigə] (чинийх, Мо.činüki) < qini [tɕini] (чиний, Мо.činü)

gan-ni-ge [ɣannigə] (“түүнийх”, Мо.tegünüki)

< gan-ni [ɣanni] (“түүний”, Мо.tegün-ü) < gan [ɣan] (“тэр”, Мо.tere)

gansi-ni-ge [ɣansnigə] (“тэднийх”, Мо.tedenüki)

< gansi-ni [ɣansni] (“тэдний”, Мо.teden-ü) < gansi [ɣansi] (“тэд”, Мо.tede)

1.7 -gui [-gui] (Kh.-гүй, Mo.ügei)

Тус дагавар нь “юмны шинж чанарыг үгүйсгэх” утга илэрхийлсэн *privative suffix* болно.

jia-gui [dʒiaɣui] (завгүй, Мо.ʒab-ügei) < jia [dʒia] (зав, Мо.ʒab)

dura-gui [duraɣui] (дургүй, Мо.dur-a-ügei) < dura [dura] (дур, Мо.dur-a)

kuji-gui [kudziɣui] (хүчгүй, Мо.küčü-ügei) < kuji [kudzi] (хүч, Мо.küčü)

nuer-gui [nuəɣui] (“нүүрэмгий, нүүргүй”, Мо.niγur-ügei)

< nuer [nuə] (“нэр нүүр, нэр хүнд”, Мо.niγur)

1.8 -ghulu [-gulu] (Хам тооны Kh.-уул/-үүл, Мо.-γula/-güle дагавартай гарал нэгтэй байсан болов уу гэж таамаглаж байна)

Тус дагавар нь “тухайн юмаар элбэг баян, их олон, дүүрэн, нэл тийм юм(тай)” гэх мэтийн утга санааг илтгэнэ. Энэ нь Миньхэ монгол хэлний үйлдэхийн тийн ялгалын *-ghulu* нөхцөлтэй ижил хэлбэртэй байгааг онцлон дурдууштай байна.

tashi-ghulu [taʃigulu] (“чулуу ихтэй, чулуурхаг”)

< tashi [taʃi] (Tur.taʃ “чулуу”, Tur: Түрэг хэл)

qier-ghulu [tɕiə-gulu] (“мөнгө ихтэй, мөнгөтэй”) < qier [tɕiə] (“мөнгө зоос”)

kong-ghulu [koŋgulu] (хүн ихтэй) < kong [koŋ] (хүн, Мо.kümün)

wolian-ghulu [wolianɣulu] (үүл ихтэй, үүлэрхэг)

< wolian [wolian] (үүл(эн), Мо.egüle(n))

khuerghai-ghulu [quə-ɣaigulu] (хорхой ихтэй)

< khuerghai [quə-ɣai] (хорхой, Мо.ɣoɣuɣai)

shao-ghulu [ʃaogulu] (шороо ихтэй, нэл шороо(той))

< shao [ʃao] (шороо, Мо.sirui)

shiber-ghulu [ʃibə] (шавар ихтэй, нэл шавар(тай))

< shiber [ʃibə] (шавар, Мо.sibar)

1.9 -her [-хә] (Kh. -, Mo. -)

Тус дагаврыг өнгө заасан зарим нэр үг юм уу, тэмдэг нэр үгэнд залгаж хүч нэмэгдүүлэх утгатай “улам~, илүү~, нэлээд~” гэх зэргийн санааг оруулна. Хэлбэрийн хувьд үүнд таарахуйц дагавар байдаг эсэх нь орчин цаг болон дундад зууны үеийн монгол хэлэнд огт батлагдаагүй учир Миньхэ монгол хэлний өвөрмөц дагавар мөн гэж үзэж байна.

① Өнгө заасан нэр үгэнд залгасан нь:

chighang-her [tʃiɡaŋxə] (улам цагаан) < chighang [tʃiɡaŋ] (цагаан, Mo.čayan)

khara-her [qaraχə] (улам хар) < khara [qara] (хар, Mo.qar-a)

hulang-her [xulaŋxə] (улам улаан) < hulang [xulaŋ] (улаан, Mo.(h)ulayan)

sha-her [ʃaχə] (улам шар) < sha [ʃa] (шар, Mo.sir-a)

② Тэмдэг нэр үгэнд залгасан нь:

gezai-her [gəɕzaiχə] (илүү сайн) < gezai [gəɕzai] (сайн, Mo.sayin)

wulan-her [wulaŋxə] (илүү олон) < wulan [wulaŋ] (олон, Mo.olan)

naren-her [naɾəŋxə] (илүү нарийн) < naren [naɾəŋ] (нарийн, Mo.narin)

1.10 -ker [-кә] (Үйлдэхийн тийн ялгалын Kh.-аар⁴, Mo.-bar/-ber (~ -yar/-ger) нөхцөлтэй гарал нэгтэй байсан болов уу гэж таамаглаж байна)

Тус дагаврыг заах төлөөний нэр болон зарим асуух төлөөний нэр үгэнд залгаж, “тухайн юмны хавьд, хавиар” гэсэн утга санааг илтгэнэ.

ni-ker [nikə] (үүгээр, энэ хавиар, Mo.egüber < *e-gü-ber)

< ni [ni] (энэ, Mo.ene < *e-)

ti-ker [tikə] (түүгээр, тэр хавиар, Mo.tegüber < *te-gü-ber)

< ti [ti] (тэр, Mo.tere < *te-)

taoti-ker [taotikə] (тээр тэр хавиар, тээр тэнд)

< taoti [taoti] (< *teete < тээр тэр)

ali-ker [alikə] (аль хавьд) < ali [ali] (аль, Mo.ali)

1.11 -ku [-ку] (Kh.-х, Mo.-ki (> Kh.-дахь/-дэх, Mo.-daki/-deki))

Тус дагаврыг тодорхой газар юм уу, цаг заасан нэр үгэнд залгаж “тухайн юмны утга бүхий” буюу “тухайн газарт байгаа~, тухайн цагийн~” гэх мэтийн санааг илтгэнэ.

ger-ku kong [gəku koŋ] (1.гэрийнхэн, 2.гэргий)

< ger [gə] (гэр), kong [koŋ] (хүн)

ning-ku kong [niŋku koŋ] (эндэхийн хүн)

< ni [ni] (энэ), kong [koŋ]

ghada-ku kong [ɕadaku koŋ] (гаднын хүн)

< ghada [ɕada] (гадаа), kong [koŋ]

shidie-ku yama [ʃidiə-ku jama] (өглөөний хоол (~цай))

< shidie [ʃidiə] (эрт “өглөө”), yama [jama] (юм “хоол”)

buleghe-ku suzu [buləɕə-ku sudzu] (булгийн ус)

< buleghe [buləɕə] (булаг), suzu [sudzu] (ус)

Дашрамд хэлэхэд энэ дагавар нь гарал үүслийн хувьд дээр дурдсан 1.6 -ge [-gə] дагавартай гарал нэгтэй. Аль аль нь *-ki дагавраас хөгжсөн бөгөөд хэрэглээний хувьд өөр үүрэгтэй хоёр дагавар болж хувирч ирсэн гэж таамаглаж байна. Тус хоёр дагавар орчин цагийн монгол хэлэнд -х (< Mo.-ki) гэсэн нэг л хэлбэртэй байгаагаас үзэхэд энэ нь Миньхэ монгол хэлний өвөрмөц хөгжил буюу шинэчлэл гэж үзэж болох байна.

1.12 -qi [-tɕi] (Kh.-ч ∞ -чин, Mo.-či ∞ -čín)

Тус дагаврыг зарим нэр үгэнд залгаж, тухайн үйл явдлын эзэн, тухайн ажлыг эрхлэгч гэсэн санааг илтгэнэ.

ghuder-qi [gudə-tɕi] (худалч, Mo.qudalči) < ghuder [gudə] (худал, Mo.qudal)

zhuangjia-qi [dʒuɑŋdʒiatei] (“тариачин”)

< zhuangjia [dʒuɑŋdʒia] (< Ch. 庄稼 zhuangjia “тариа”)

khuerghai-qi [quə-ɕaitɕi] (хулгайч, Mo.qulayaiči)

< *khuerghai (дангаар нь хэрэглэдэггүй) (хулгай, Mo.qulayai)

Орчин цагийн монгол хэлэнд маш идэвхтэй хэрэглэгддэг тус дагавар нь Миньхэ монгол хэлэнд харьцангуй бага хэрэглэгддэг онцлогтой байна. Энэ байдлаас үзэхэд монгол төрөл хэлнүүдэд ер нь дагаврын давтамж нь хэл хэлэнд өөр өөр байдгийг харуулж байна.

1.13 -si [-sɪ] (Kh.-с, Mo.-s)

Тус дагавар нь Миньхэ монгол хэлний нэр үгийн олон тооны дагавар мөн бөгөөд тус хэлэнд маш идэвхтэй түгээмэл хэрэглэгддэг онцлогтой.

① Хүн заасан нэр үгэнд залгасан нь:

nongkong-si [noŋkoŋsɪ] (“(гэр бүлтэй) эрэгтэйчүүд”)

< nongkong [noŋkoŋ] (“(гэр бүлтэй) эрэгтэй”)

shinagu-si [ʃinaɣusɪ] (“(гэр бүлтэй) эмэгтэйчүүд, авгай нар”)

< shinagu [ʃinaɣu] (“(гэр бүлтэй) эмэгтэй, авгай”)

bulai-si [bulaisɪ] (“эрэгтэй хүүхдүүд”) < bulai [bulai] (“эрэгтэй хүүхэд”)

aguer-si [aɣuə-sɪ] (“эмэгтэй хүүхдүүд”) < aguer [aɣuə] (“эмэгтэй хүүхэд”)

kaohujun-si [kaɔɕudzynsɪ] (“хүүхдүүд”)

< kao [kaɔ] (хүү, Mo.köbögün, küü), hujun [ɕudzyn] (охин, Mo.ökin)

② Хүнээс бусад юм заасан нэр үгэнд залгасан нь:

wula-si [ulasɪ] (уулс) < wula [ula] (уул, Mo.aɣula)

wolian-si [woliansɪ] (үүлс) < wolian [wolian] (үүл, Mo.egüle(n))

niere-si [niərəsɪ] (нэрс) < niere [niərə] (нэр, Mo.ner-e)

huguer-si [xuɣuə-sɪ] (үхрүүд) < huguer [xuɣuə] (үхэр)

yama-si [jamasi] (“хоолнууд”) < yama [jama] (“хоол”, юм, Mo.yaɣum-a)

Орчин цагийн монгол хэлэнд -ууд (~ -нууд), -д, -с, -чууд (~ -чуул), -нар зэрэг олон тоог илтгэх дагаврууд байдаг. Үүний дотроос -д хэлбэр нь маш идэвхтэй, түгээмэл хэрэглэгддэг үндсэн дагавар. Харин -с хэлбэр нь эдүгээ бага хэрэглэгддэг ч, эртний монгол хэлэнд харьцангуй идэвхтэй дагавар байсан бололтой. Учир иймээс Миньхэ монгол хэлэнд

нэг л янзын -si [-si] (< *-s) дагавар хэрэглэгддэг нь тус хэлний нэг ёсны хэмнэлт бөгөөд шинэчлэл гэж болно.

1.14 -tai [-tai] (Kh.-тай³, Mo.-tai/-tei)

Тус дагаврыг нэр үгэнд залгаж, “тухайн юм бүхий, тухайн юмыг агуулсан” гэсэн утга санааг илэрхийлдэг бөгөөд тус хэлэнд харьцангуй өргөн хүрээтэй хэрэглэдэг. Үүргээр нь хувааж жишээгээр үзүүлбэл:

① Бодит юмны эзэмшил, харьяалал бүхий:

ger-tai [gətai] (гэр бүхий) < ger [gə] (гэр, Mo.ger)

terge-tai [tiəgətai] (“унаа тэрэг” бүхий) < terge [tiəgə] (тэрэг, Mo.terge)

② Тухайн юмыг өмссөн байдалтай:

hai-tai [xaitai] (“гуталтай, гутал өмссөн”) < hai [xai] (Ch. 鞋 (漢音 kai))

wazi-tai [wadzitai] (“оймстой, оймс өмссөн”) < wazi [wadzi] (Ch. 袜子 wazi)

③ Хийсвэр юмны утга, чанар бүхий:

kuji-tai [kudžitai] (хүчтэй) < kuji [kudzi] (хүч, Mo.kücü)

dura-tai [duratai] (дуртай) < dura [dura] (дур, Mo.dur-a)

jia-tai [dʒiatai] (завтай) < jia [dʒia] (зав, Mo.jab)

nasi-tai [nasitai] (настай) < nasi [nasi] (нас, Mo.nasu)

aqi-tai [ateitai] (ач тустай) < aqi [atei] (ач, Mo.açi)

niere-tai [niəretai] (нэр алдартай) < niere [niəgə] (нэр, Mo.ner-e)

1.15 -tang [-taŋ] (Kh.-тан⁴, Mo.-tan/-ten)

Тус дагавар нь голдуу ахмад хүнийг заасан ураг төрлийн нэр үгэнд залгаж, “тухайн хүнийг төлөөлсөн хамт олон, тэдний гэрийнхэн” гэсэн утга санааг илтгэнэ.

gaga-tang [gagataŋ] (“ах нар, ахынхан”)

< gaga [gaga] (Ch. 哥哥 gege)

awu-tang [awutaŋ] (“авга ах нар, авга ахынхан”)

< awu [awu] (“авга ах”)

aye-tang [ajətaŋ] (“өвөө нар, өвөөгийнхэн”)

< aye [ajə] (“өвөө”)

niana-tang [nianataŋ] (“эмээ нар, эмээгийнхэн”)

Дээр дурдсан олон тоо заах 1.13 -si [-si] дагавартай харьцуулахад энэхүү -tang [-taŋ] дагавар нь голдуу ахмад хүнийг заасан нэр үгэнд залгагдаараа “хүндэтгэл”-ийн утгыг агуулж байгаа нь тодорхой бөгөөд утгын хүрээ ч арай өргөн байгаагаараа эрс ялгаатай гэж болно.

Бас орчин цагийн монгол хэлний -тан⁴ (Mo.-tan/-ten) дагавар нь 1-т “тухайн юмны утга бүхий бүлэг” (жишээ нь: амьтан (амь бүхий бүлэг) < амь, эрдэмтэн (эрдэм бүхий бүлэг) < эрдэм г.м.), 2-т “хүндэтгэлийн утга агуулсан” (жишээ нь: хаантан (хааны хүндэтгэл) < хаан, ламтан (ламын хүндэтгэл) < лам г.м.) гэсэн хоёр төрлийн утга илэрхийлдэг. Үүнтэй тохиролцох Миньхэ монгол хэлний -tang [-taŋ] дагавар нь дээр дурдсанчлан утгын хувьд

“1.олон тоо, 2.хүндэтгэл”-ийн аль алиныг нь агуулж байгаагаас үзэхэд, эртний монгол хэлний уг утгыг зохих хэмжээгээр сайн хадгалж хөгжүүлсний үр дүн байх гэж таамаглаж байна.

1.16 -tang [-taŋ] (Kh.-(н)гаа⁴, Mo.-ta/-te)

Тус дагавар нь орчин цагийн монгол хэлний “хэдэн удаа” гэсэн асуултанд хариулах “дахих тооны дагавар” -(н)гаа⁴ хэлбэртэй нэг гаралтай байх.

yi-tang [jiŋ] (“нэг удаа”) < yi [ji] (Ch. 一 yi)

liang-tang [liɑŋŋ] (“хоёр удаа”) < liang [liɑŋ] (Ch. 兩 liang)

san-tang [sɑŋŋ] (“гурван удаа”) < san [sɑŋ] (Ch. 三 san)

si-tang [siŋŋ] (“дөрвөн удаа”) < si [si] (Ch. 四 si)

2. Үйлээс нэр бүтээх дагавар (V → N)

Миньхэ монгол хэлний үйлээс нэр бүтээх гол дагавруудыг доор үзүүлэв.

2.1 -a [-ɑ] (Kh.-aa⁴, Mo.-ya/-ge ~ -ya/-ye)

Тус дагаврыг цөөн үйл үгэнд залгаж, хийсвэр утга бүхий нэр үг үүсгэдэг. Орчин цагийн монгол хэлэнд энэхүү -aa⁴ дагавар нь хийсвэр утгыг илэрхийлдэг үйлээс нэр бүтээхэд хамгийн идэвхтэй хэрэглэгддэг байхад Миньхэ монгол хэлэнд маш идэвхгүй хэрэглэгддэг гэсэн тодорхой ялгаа байна.

tar-a [tɑɑ] (тариа, Mo.tariy-a) < tari- [tɑri-] (тарь-, Mo.tari-)

2.2 -der [-dɛ] (Kh.-дал⁴, Mo.-dal/-del)

Тус дагаврыг зарим цөөн үйл үгэнд залгаж, тухайн үйлийн үр дүнд бий болсон хийсвэр утга бүхий нэр үг үүсгэнэ.

you-der [jɔudɛ] (явдал “явах байдал, хөдөлгөөн”, Mo.yabu-dal)

< you- [jɔu-] (ява-, Mo.yabu-)

keli-der [kɛlidɛ] (“муу нэр”, Mo.*kele-del)

< keli- [kɛli-] (хэлэ-, Mo.kele-)

2.3 -er [-ɛ] (Kh.-уур/-үүр, Mo.-yur/-gür)

Тус дагаврыг цөөн үйл үгэнд залгаж, багаж хэрэгслийн нэр үг үүсгэнэ. Орчин цагийн монгол хэлэнд маш идэвхтэй, өргөн хүрээтэй хэрэглэгддэг энэхүү -уур/-үүр дагавар нь Миньхэ монгол хэлэнд харин ч идэвхгүй дагаварт тооцогдох их ялгаа байна.

ghaduer [ɣɑduɛ] (хадуур, Mo.qaduɣur)

< ghadu- [ɣɑdu-] (“хярга-” хада-, Mo.qadu-)

2.4 -ger [-gɛ] (? Kh.-вар⁴, Mo.-buri/-büri)

Тус дагаврыг цөөн үйл үгэнд залгаж, хийсвэр утга бүхий нэр үг үүсгэнэ. Энэхүү дагаврыг орчин цагийн монгол хэлний ямар дагавартай гарал нэгтэйг батлан хэлэхэд тун

бэрх байгаа боловч авиа зүйн хувьд $b \sim g$ сэлгэх боломжтой бөгөөд утгын хувьд ч хийсвэр утга илэрхийлэх нийтлэг онцлогийг агуулж байгаа учир одоохондоо Мо.-buri/-būri (жишээ нь: чадвар < чада-, тээвэр < тээ- г.м.) дагавартай гарал нэг гэж үзэж байна.

nadu-ger [nadugə-] (1.наадгай, 2.наадам (наргиан), ? Мо.*naγad-u-buri)
< nadu- [nadu-] (наад-, Мо.naγad-)

2.5 -kuni [-kuni] (< *V-ku N (> Ø)-ni, Kh.V-х юм)

Тус дагавар нь үйл үгэнд залгаж, “тухайн үйлийг хийх юм” гэсэн утгатай нэр үг бүтээх нэлээд давтамжтай дагавар мөн. Бүтцийн хувьд авч үзвэл *V-ku* (үйлт нэрийн нөхцөл Мо.-qu/-kü) дээр *N* (жишээ нь *dongxi* [doŋxi] (< Ch.东西 “юм”) гэх мэтийн нэр үг байж байгаад хожим тэр нь гээгдсэн болов уу) нэмж, араас нь 3-р биеийн төлөөний нөхцөл *-ni* залгасан **V-ku N (> Ø)-ni* хэлбэр хураагдсанаас энэхүү *-kuni* дагавар үүссэн байх гэж таамаглаж байна.

di-kuni [dikuni] (идэх юм, идээ) < di- [di-] (идэ-, Мо.ide-)
wu-kuni [ukuni] (уух юм, ундаа) < wu- [u-] (уу-, Мо.uuyu-)
musi-kuni [musikuni] (өмсөх юм, хувцас) < musi- [musi-] (өмс-, Мо.emüs-)
budu-kuni [budukuni] (будах юм, будаг) < budu- [budu-] (буда-, Мо.budu-)
nadu-kuni [nadukuni] (“тоглоом”) < nadu- [nadu-] (наад-, Мо.naγad-)

2.6 -lang [-laŋ] (Kh.-лан(r)⁴, Мо.-lang/-leng)

Тус дагаврыг маш цөөн үйл үгэнд залгаж, хийсвэр утгатай нэр үг үүсгэнэ.
zhuobulang [dʒuobulaŋ] (“төвөг” зовлон, Мо.jobalang)
> zhuobo- [dʒuobo-] (“1.ажиллах, 2.хичээх” зово-, Мо.jobā-)

2.7 -qin [-tein] (Kh.-гч, Мо.-γči/-gči (V → N) < *-γ/-g (V → N) + -či(n) (N → N)

cf. Kh.-ч(ин), Мо.-či(n) (N → N))

Тус дагавар нь үйл үгэнд залгаж, “тухайн үйлийг хийх хүн” гэсэн утгатай нэр бүтээдэг нэлээд давтамжтай дагавар юм. Бүтцийн хувьд авч үзвэл Баоан -teŋj ~ -teŋj, Дуншаан -tʂəŋj, Монгол (Хүжү) -dʒin, (Миньхэ) -tein гэж бараг жигд гардгийг үндэслэж, **-γ/-g (V → N) + -či(n) (N → N) > -γ/-g (> Ø) -čín > -čín (V → N)* гэх мэтээр хувирч ирсэн байх гэж таамаглаж байна.

kerli-qin [kəli-tein] (“гуйлгачин”) < kerli- [kəli-] (“хүсэх, хэрэгтэй байх”)
daola-qin [daolatein] (“дуучин”) < daola- [daola-] (дуула-, Мо.daγula-)
di-qin [ditein] (идэх хүн) < di- [di-] (идэ-, Мо.ide-)
nadu-qin [nadutein] (“жуулчин”) < nadu- [nadu-] (наад-, Мо.naγad-)
asi dangla-qin [asidaŋlatein] (“мал хариулагч, малчин”)
< asi [asi] (“мал”), dangla- [daŋla-] (< Ch. 当 dang “хариуца-”)

2.8 -si [-sɪ] (Kh.-с(ан)⁴, Мо.-su(n)/-sü(n))

Тус дагаврыг үйл үгэнд залгаж, “тухайн үйлийн үр дүнд бий болсон юм” гэсэн утга

санааг илэрхийлнэ.

ba-si [basɪ] (баас(ан), Mo.baγasu(n)) < ba- (баа-, Mo.baγa-)
 sher-si [ʃə-sɪ] (шээс(эн), Mo.sigesü(n)) < sher- [ʃə-] (шээ-, Mo.sige-)
 hongghu-si [xоŋɣusɪ] (унгас(ан) “гэдэснээс гарах хий”, Mo.(h)ungγasu(n))
 < hongghu- [xоŋɣu-] (унга-, Mo.(h)ungγa-)
 kuoler-si [kuolə-sɪ] (хөлс, Mo.kölüsü) < kuoler- [kuolə-] (хөлрө-, Mo.kölüre-)

3. Нэрээс үйл бүтээх дагавар (N → V)

Миньхэ монгол хэлний нэрээс үйл бүтээх гол дагавруудыг доор үзүүлэв.

3.1 -da- [-da-] (Kh.-да⁴-, Mo.-da-/de-)

Тус дагаврыг нэр үгэнд залгаж, доорх утга бүхий үйл үгүүдийг үүсгэнэ.

- ① “Тухайн юмаар үйлдэх, тухайн юмыг хэрэглэх” гэсэн утгатай:
 tashi-da- [taʃida-] (“чулуугаар цохих, чулуудах”)
 < tashi [taʃi] (Tur.taʃ “чулуу”)
 miela-da- [miələda-] (“малиа (ташуур)аар цохих, ташуурдах”)
 < miela [miəla] (“малиа (ташуур)”)
 dao-da- [daoda-] (дууда-, Mo.daγuda-) < dao [dao] (дуу, Mo.daγu)
- ② “Хэтэрхий тийм болох, хэтрэх” гэсэн утгатай:
 khalong-da- [qalɔŋda-] (“хэтэрхий халуун болох” халууда-, Mo.qalaγuda-)
 < khalong [qalɔŋ] (халуун, Mo.qalaγun)
 kuitian-da- [kuitianda-] (“хэтэрхий хүйтэн болох” хүйтдэ-, Mo.küitede-)
 < kuitian [kuitian] (хүйтэн, Mo.küiten)
 wulan-da- [ulanda-] (“хэтэрхий олон болох” олдо-, Mo.olada-)
 < wulan [ulan] (олон, Mo.olan)
 chuang-da- [ʃuaŋda-] (“хэтэрхий цөөн болох” цөөдө-, Mo.čögede-)
 < chuang [ʃuaŋ] (цөөн, Mo.čögen)
 shuduer-da- [ʃuduəda-] (“хэтэрхий урт болох” уртда-, Mo.urtuda-)
 < shuduer [ʃuduə] (урт, Mo.(h)urtu)
 shuguo-da- [ʃuɣuoda-] (“хэтэрхий том болох” ихдэ-, Mo.yekede-)
 < shuguo [ʃuɣuo] (“том” их, Mo.yeke)

Жич: Орчин цагийн монгол хэлэнд нэр үг, тухайлбал тэмдэг нэрд үйл бүтээх дагавар, жишээ нь -да-, -ра- гэх мэтийг залгахад тэмдэг нэрийн төгсгөлийн -н (анхдагч үндэс үүсгэгч / primary stem-formative) нь ер нь бүрэн гээгддэг байхад Миньхэ монгол хэлэнд энэхүү -н нь гээгддэггүй, хадгалагдсан байдгаараа хоёр хэлний үг бүтэх ёс нь ялгаатай байгааг анхаарууштай байна.

- ③ “Өөрөө аяндаа тийм болох” гэсэн утгатай:
 gui-da- [guida-] (үгүйдэ- “1.үгүй болох, 2.үхэх”) < gui [gui] (үгүй, Mo.ügei)
 kharongghu-da- [qarɔŋɣuda-] (харанхуй болох)
 < kharongghu [qarɔŋɣu] (харанхуй, Mo.qarangqui~qarangγui)

wurai-da- [uraida-] (оройто-) < wurai [urai] (орой, Mo.orui)
 duoysi-da- [duojida-] (“илүүдэ-”) < duoysi [duoji] (Ch. 多余 duoюу “илүү”)

3.2 -la- [-la-] ~ -luo- [-luo-] ~ -li- [-li-](∞ -lie- [-liə-]) (Kh.-ла⁴-, Mo.-la-/-le-)

Орчин цагийн монгол хэлний нэрээс үйл бүтээх дагаврын дотор хамгийн идэвхтэй хэрэглэгддэг энэхүү -ла⁴- дагавар нь Миньхэ монгол хэлэнд ч өргөн хүрээтэй хэрэглэгддэг байна.

Миньхэ монгол хэлэнд ер нь эгшиг зохицох ёс нэгэнт байхгүй болсон гэж хэлж болох боловч энэхүү дагаврын тухайд эгшиг зохицох ёсны ул мөрийг эдүгээ хүртэл арайхан хадгалсаар ирсэн гэж болмоор байна. Үүнд *-a-/*-u- (үйл үгийн үндсэн эгшиг) > -la- (N → V дагавар), *-o- > -luo-, *-e-/*-ö-/*-ü- > -li- (∞-lie-) гэсэн ерөнхий дүрэм үйлчилж буйг ажиглаж болно.

Энэ дагаврыг гүйцэтгэх үүргийн талаас авч үзвэл дараах хэдэн зүйлээр хувааж болох байна.

① Жинхэнэ нэрээс тусах үйл үг үүссэн нь:

dao-la- [daola-] (дуула-, Mo.dayula-) < dao [dao] (дуу, Mo.dayu)
 sangmu-la- [saŋmula-] (самна-, Mo.samna-) < sang [saŋ] (сам, Mo.sam)
 cherghuo-luo- [tʃəʁuoluo-] (“гинжлэ-”) < cherghuo [tʃəʁuo] (“гинж”)
 nudu-li- [nuduli-] (“хялайж харах” нүдлэ-, Mo.nidüle-)
 < nudu [nudu] (нүд, Mo.nidü)
 jiaodong-li- [ʃiaodongli-] (зүүдлэ-, Mo.jegüdüle-)
 < jiaodong [ʃiaodong] (зүүд(эн), Mo.jegüdü(n))

② Жинхэнэ нэрээс эс тусах үйл үг үүссэн нь:

burer-la- [burəla-] (“тугалла-”, Mo.*birayu-la-)
 < burer [burə] (бярүү, Mo.birayu)
 qijighe-li- [teidʒicəli-] (цэцэглэ-, Mo.čecəgle-)
 < qijighe [teidʒicə] (цэцэг, Mo.čecəg)
 andige-li- [andigəli-] (өндөглө-, Mo.öndegele-)
 < andige [andigə] (өндөг, Mo.öndege)
 nukuer-li- [nukuəli-] (“1.нөхөр болох, 2.туслах” нөхөрлөх, Mo.nökürle-)
 < nukuer [nukuə] (нөхөр, Mo.nökür)

③ Тэмдэг нэрээс үйл үг үүссэн нь:

sha-la- [ʃala-] (шарла-, Mo.sirala-) < sha [ʃa] (шар, Mo.sir-a)
 khara-la- [qarala-] (харла-, Mo.qarala-) < khara [qara] (хар, Mo.qar-a)
 terghu-la- [təʁula-] ((мал амьтан дээр) таргала-, Mo.taryula-)
 < terghong [təʁoŋ] (“(хоол, махан дээр) өөхтэй” тарган, Mo.taryun)

④ Хятад гаралтай үгнээс үйл үг үүссэн нь:

huangla- [xuɑŋla-] (“завгүй байх”) < huang [xuɑŋ] (Ch. 慌 huang)
 shua-la- [ʃuala-] (“сойздох”) < shua [ʃua] (Ch. 刷 shua)
 yangjila- [jaŋdzila-] (“гуйх”) < yangji [jaŋdzi] (Ch. 央求 yangqiu)

cuo-luo- [tsuoluo-] (“андуурах”) < cuo [tsuo] (Ch. 錯 cuo)
 bian-li- [bianli-] (“хувирах, өөрчлөгдөх”) < bian [bian] (Ch. 变 bian)
 zheng-li- [dzəŋli-] (жигнэх, Mo. jingne- (< *jing-le-))
 < zheng [dzəŋ] (Ch. 蒸 zheng)
 jie-lie- [dziəliə-] (зээлэх, Mo. jigele-) < jie [dziə] (Ch. 借 jie)

3.3 -ra- [-ra-] ~ -ruo- [-ruo-] ~ -re- [-rə-] (∞ -ri- [-ri-]) (Kh.-pa⁴-, Mo.-ra-/-re-)

Тус дагаврыг нэр үг, тухайлбал тэмдэг нэрд залгаж, “өөрөө аяндаа тийм болох” гэсэн утга бүхий эс тусах үйл үг үүсгэнэ.

Дээр 3.2-т дурдсан -la- [-la-] гэх мэтийн дагавартай адил, энэхүү дагавар ч зохих хэмжээгээр эгшиг зохицох ёсны ул мөрийг хадгалж байгаа бөгөөд бүдүүвчлэн хэлэхэд *-a- (үйл үгийн үндсэн эгшиг) > -ra- (N → V дагавар), *-o- > -ruo-, *-e-/*-ö- > -re- (∞ -ri-) гэсэн ерөнхий дүрмийг дагаж байгаа нь ажиглагдаж байна.

chighai-ra- [tʃiçairə-] (цагаара-, Mo. çayara-)
 < chighang [tʃiçaŋ] (цагаан, Mo. çayān)
 kuangan-ra- [kuanganra-] (хөнгөрө-, Mo. könggere-)
 < kuangan [kuangan] (< *konggon < *könggen / хөнгөн, Mo. könggen)
 nuoghuo-ruo- [nuoçuo-] (ногооро-, Mo. noçuyara-)
 < nuoghuang [nuoçuaŋ] (ногоон, Mo. noçuyān)
 kuitie-re- [kuitiərə-] (хүйтрэ-, Mo. küitere-)
 < kuitian [kuitian] (хүйтэн, Mo. küiten)
 geige-re- [gəiçərə-] (гэгээрэ-, Mo. gegere-)
 < geigan [gəiçan] (гэгээн, Mo. gegen)
 kugu-ri- [kuçuri-] (хөхрө-, Mo. kökere-)
 < kuguo [kuçuo] (хөх, Mo. köke)

Жич: Миньхэ монгол хэлэнд *nerri-* [nə-ri-] (“унтах”) гэсэн үндсэн үйл үг бий бөгөөд энэ нь *ner* [nə] (нойр, Mo. noyir) гэсэн нэр үгэнд энэхүү -ri- дагавар залгаж бүтсэн үүсмэл үйл үг мэт санагдавч үнэндээ тийм биш, харин араас нь үйл үг *ri-* [ri-] (ирэ-, Mo. ire-) залгасан нийлмэл үйл үг мөн гэж үзэж байна. Үүнд *ner* [nə] (нойр) + *ri-* (ирэх) > *nerri-* [nə-ri-] (“унтах”).

3.4 -tu- [-tu-] (хэлбэр нь: Kh.-ta⁴-, Mo.-tu-/-tü-, cf. утга нь: Kh.-d-, Mo.-d-)

Тус дагаврыг нэр үг, тухайлбал тэмдэг нэрд залгаж, “өөрөө аяндаа тийм болох” гэсэн утга бүхий эс тусах үйл үг үүсгэнэ.

Орчин цагийн монгол хэлний энэхүү -ta⁴- дагавар нь “өөрөө аяндаа тийм болох” гэсэн утгатайгаас гадна, бас “тухайн юм бий болох, тухайн юмтай болох” (жишээ нь: хорхойто- (өт хорхой бий болох) < хорхой г.м.) гэсэн гол утгыг илэрхийлдэг. Гэтэл Миньхэ монгол хэлэнд жинхэнэ нэрд энэхүү дагавар залгасан жишээ тун цөөн буюу сүүлчийнх нь утгаар маш бага хэрэглэгддэгээс хоёр хэл өөр өөр чиглэлээр хөгжсөн гэж болно.

① Тэмдэг нэрд залгасан нь:

Утгын хувьд авч үзвэл энэхүү дагавар нь орчин цагийн монгол хэлний -д- (~ -с-) дагавартай тохиролцох нь олонтоо байна.

- shuguo-tu- [ʃuɡuoʈu-] (“том болох” ихэд-, Мо.уекед-)
 < shuguo [ʃuɡuo] (“том” их, Мо.уеке)
 khalong-tu- [qalɔŋtu-] (“халуун болох” халууд-, Мо.qalayud-)
 < khalong [qalɔŋ] (халуун, Мо.qalayun)
 kuitian-tu- [kuitiantu-] (“хүйтэн болох” хүйтэд-, Мо.küited-)
 < kuitian [kuitian] (хүйтэн, Мо.küiten)
 wulan-tu- [ulantu-] (“олон болох” олод-, Мо.olad-)
 < wulan [ulan] (олон, Мо.olan)
 chuang-tu- [tʃuaŋtu-] (“цөөн болох” цөөд-, Мо.čöged-)
 < chuang [tʃuaŋ] (цөөн, Мо.čögen)

Жич: Дээр дурдсан 3.3 -*ra*- [-ra-], 3.4 -*tu*- [-tu-] хоёр дагаврын илэрхийлэх үндсэн утга нь адилхан (жишээ нь: *kuitie-re-*, *kuitian-tu-* “хүйтэн болох” < *kuitian* г.м.) боловч утгын нарийн ялгаа бий эсэхийг цаашдаа судлууштай байна.

② Жинхэнэ нэрд залгасан нь:

- boruo-tu- [boruoʈu-] (“бүрхэх, үүлших” Мо.*boruʧa-tu-)
 < *boruo (бороо, Мо.boruʧa)

Энэ үгийг тус хэлэнд дангаар нь хэрэглэдэггүй, харин бороо гэсэн утгаар *khura* [qura] гэсэн үгийг хэрэглэдгийг анхаарна уу.

3.5 -ke- [-kə-] (Kh. - , Mo. -)

Тус дагаврыг хятад гаралтай зарим үгэнд залгаж, тухайн үгийн утга бүхий үйл үг үүсгэнэ. Энэхүү үг бүтэх ёс нь орчин монгол хэлэнд ер харагддаггүй учир Миньхэ монгол хэлний өвөрмөц арга, нэг ёсны шинэчлэл гэж болох байна. Гэвч эргэн тойрны монгол төрөл хэлнүүд, тухайлбал Баоан, Дуншаан, Канжаа, Хүжү монгол гэх мэтийн хэлний тус байдлыг тодруулахгүйгээр яаран дүгнэж болохгүй нь лавтай.

- kai-ke- [kaike-] (“эхлэх”) < kai [kai] (Ch. 开 kai)
 la-ke- [lake-] (“тагах”) < la [la] (Ch. 拉 la)
 ma-ke- [make-] (“арчих”) < ma [ma] (Ch. 抹 ma)
 tang-ke- [tangkə-] (“хэвтэх”) < tang [taŋ] (Ch. 躺 tang)
 wa-ke- [wake-] (“малтах”) < wa [wa] (Ch. 挖 wa)

Миний ажигласнаар Миньхэ монгол хэлний энэхүү дагаврын өвөрмөц онцлог нь юу вэ гэвэл зарим үйл үгэнд -*qi*- [-tei-] ~ -*ke*- [-kə-] хоёр дагаврын сэлгэлт байгаа бөгөөд Миньхэ монгол хэлээр яригч эрэгтэй хүн нь -*qi*- [-tei-] хэлбэрийг илүү их хэрэглэдэг бололтой. Тус хэлний энэхүү үзэгдлийг бас л Миньхэ монгол хэлний нэг ёсны шинэчлэл гэж болох байна.

- erqi- [ətei-] (эрэгтэй хүний хэллэг / “хөлс арчих” арчи-, Мо.arci-)
 ~ erke- [əkə-] (энгийн үг)
 nuoqi- [nuotei-] (эрэгтэй хүний хэллэг / “цаг өнгөрөх” нөгчи-, Мо.nögci-)

- ~ nuoke- [nuokə-] (энгийн үг)
 tangke- [taŋkə-] (Ch. 躺 tang “хэвтэх”) (энгийн үг)
 ~ tangqi- [taŋtei-] (эрэгтэй хүний хэллэг)

4. Үйлээс үйл бүтээх дагавар (V → V)

Миньхэ монгор хэлний үйлээс үйл бүтээх гол дагавруудыг доор үзүүлэв.

4.1 -gha- [-ga-](хэлбэр нь: Kh.-га⁴- (Mo.-ya-/ge- ~ -qa-/ke-), cf. хувилбар нь: Kh.-aa⁴- (Mo.-ya-/ge-) ~ Kh.-yul²- (Mo.-yul-/göl-) ~ Kh.-lga⁴- (Mo.-lyā-/lge-))

Тус дагавар нь Миньхэ монгор хэлний үйлдүүлэх хэвийн дагавар мөн бөгөөд орчин цагийн монгол хэлэнд -aa- ~ -ga- ~ -yul- ~ -lga- гэсэн үйлдүүлэх хэвийн дөрвөн хувилбартай байхад Миньхэ монгор хэлэнд нэг л -gha- [-ga-] хэлбэртэй байгаа нь цуваа цагийн үүднээс үзэхэд хэлний хэмнэлтийн зарчим буюу Миньхэ монгор хэлний шинэчлэл гэж болно.

- xi-gha- [xiɣa-] (очуул-, Mo.ociyul-) < xi- [xi-] (очи-, Mo.(h)eci- ~ oci-)
 di-gha- [diɣa-] (идүүл-, Mo.idegöl-) < di- [di-] (идэ-, Mo.ide-)
 wu-gha- [wuɣa-] (уулга-, Mo.uuyulya-) < wu- [u-] (уу-, Mo.uuyu-)
 sao-gha- [saoɣa-] (суулга-, Mo.sayulya-) < sao- [sao-] (суу-, Mo.sayu-)
 ber-gha- [bɛɣa-] (болго-, Mo.bolya-) < ber- [bɛ-] (бол-, Mo.bol-)
 gher-gha- [gɛɣa-] (гарга-, Mo.yarɣa-) < gher- [gɛ-] (гар-, Mo.yar-)
 musi-gha- [musiɣa-] (өмсгө-, Mo.emüske-) < musi- [musi-] (өмс-, Mo.emüs-)
 nao-gha- [naoɣa-] (“үзүүл-”) < nao- [nao-] (“үзэ-” cf. оно-, Mo.onu-)
 berdu-gha- [bɛɣduɣa-] (“гал асаа-”) < berdu- [bɛɣdu-] (“гал аса-”)

4.2 -duer- [-duə-] (хэлбэр нь: Kh.-лда⁴-, Mo.-ldu-/ldü-, cf. утга нь: Kh.-цгаа⁴-, Mo.-čaya-/čege-)

Тус дагавар нь Миньхэ монгор хэлний “олноор хийх гэсэн утгатай үйлдэцгээх хэв” мөн бөгөөд утгын хувьд орчин цагийн монгол хэлний -цгаа⁴- гэдэгтэй, хэлбэрийн хувьд -лда⁴- гэдэгтэй таарч, Mo.-ldu- > *-du- (metathesis) > -duer- гэх мэтээр хувирч ирсэн гэж үзэж байна.

- di-duer- [diduə-] (идэцгээ-, Mo.*ide-ldü-) < di- [di-] (идэ-, Mo.ide-)
 sao-duer- [sauduə-] (сууцгаа-, Mo.*sayu-ldu-) < sao- [sao-] (суу-, Mo.sayu-)
 keli-duer- [kəliduə-] (хэлцгээ-, Mo.*kele-ldü-) < keli- [kəli-] (хэлэ-, Mo.kele-)
 chughula-duer- [tʃuɣuladuə-] (цуглацгаа-, Mo.*čuyula-ldu-)
 < chughula- [tʃuɣula-] (цугла-, Mo.čuyula-)

4.3 -da- [-da-] (< Mo.yada- (яда-) “чадахгүй” cf. Хүжү монгор ada- [ada-])

Тус дагаврыг үйл үгийн үндсэнд залгаж, “тухайн үйлийг хийж чадахгүй, хийх боломжгүй” гэсэн утга санааг илэрхийлэх үйл үг үүсгэнэ.

Хэлбэрийн хувьд авч үзвэл энэ нь “чадахгүй” гэсэн утгыг агуулсан Mo.yada- (яда-) гэсэн үйл үгнээс дагаврын үүрэгтэй хувирч ирсэн гэж болно.

naghu-da- [nacuda-] (“чадахгүй”) < naghu- [nagu-] (“чада-”)
 meidie-da- [møidiøda-] (мэдэхгүй) < meidie- [møidiø-] (мэдэ-, Мо.mede-)
 ge-da- [gøda-] (хийж чадахгүй) < ge- [gø-] (хий-, Мо.ki-)
 taibi-da- [taibida-] (тавьж чадахгүй) < taibi- [taibi-] (тавь-, Мо.talbi-)
 zhuru-da- [dzuruda-] (“бичиж чадахгүй”)
 < zhuru- [dzuru-] (“бичи-” зура-, Мо.jiru-)
 sa-da- [sada-] (“хийж бүтээж чадахгүй”)
 < sa- [sa-] (“хийж бүтээх” заса-, Мо.jasa- / Хүжү монгол sza- [sza-])

5. Сул үгээс үйл бүтээх дагавар (P → V)

Миньхэ монгол хэлний сул үгээс үйл бүтээх гол дагавруудыг доор үзүүлэв.

5.1 -(e)r- [-ø-] (Kh.-л-, Мо.-л-)

Орчин цагийн монгол хэлэнд хага, хуга, бяц, зад, нуга, суга, тас, цоо, нэвт гэх мэтийн нэг бүлгийн сул үг (үүнийг зарим эрдэмтэн “дайвар үг”, “нөхцөлгүй үгс”, “цаашид үг бүтээх дагавар залгаж болдог идэвхгүй язгуур” гэх мэтээр янз янзаар нэрлэх нь бий) байдаг бол Миньхэ монгол хэлэнд эдгээр үгсийн заримыг дангаар нь огт хэрэглэдэггүй, заавал ч үгүй ард нь зохих үйл үг бүтээх дагавар залгасан байдаг.

Тухайлбал: Миньхэ монгол хэлний зарим идэвхгүй сул үгэнд -(e)r [-ø-] дагавар залгаж, тухайн үгийн утга бүхий “тусгах үйл үг” үүсгэнэ. Хэлбэрийн хувьд авч үзвэл, монгол бичгийн хэлний үе буюу үгийн адагт орсон -l- гийгүүлэгч авиа нь Миньхэ монгол хэлэнд -r- болж хувирах дүрэмтэй байдаг учраас -l- > -r- (үнэндээ -(e)r- [-ø-] дуудлагатай) тохиолдоно.

kheghe-r- [qəgə-] (хагал-, Мо.qaɣal-) < *kheghe [qəgə] (хага, Мо.qaɣa)
 khughu-er- [quguə-] (хугал-, Мо.quɣul-) < *khughu [qugu] (хуга, Мо.quɣu)
 cize-r- [tsidzə-] (тасал-, Мо.tasul-) < *cizi [tsidzi] (тас, Мо.tasu)
 chue-r- [tʂuə-] (цоол-, Мо.čoyul-) < *chuo [tʂuo] (цоо, Мо.čoyu)

5.2 -ra- [-ra-] ~ -ruo- [-ruo-] (Kh.-pa⁴-, Мо.-ra-/-re-)

Тус дагаврыг Миньхэ монгол хэлний зарим идэвхгүй сул үгэнд -ra- [-ra-] ~ -ruo- [-ruo-] дагавар залгаж, тухайн үгийн утга бүхий “эс тусгах үйл үг” үүсгэнэ.

kheghe-ra- [qəgəra-] (хагара-, Мо.qaɣara-) < *kheghe [qəgə] (хага, Мо.qaɣa)
 khughu-ra- [quɣura-] (хугара-, Мо.quɣura-) < *khughu [qugu] (хуга, Мо.quɣu)
 cizi-ra- [tsidzira-] (тасра-, Мо.tasura-) < *cizi [tsidzi] (тас, Мо.tasu)
 chuo-ruo- [tʂuə-] (“(хувцас, цаас г.м.) урагдах” цооро-, Мо.čoyura-)
 < *chuo [tʂuo] (цоо, Мо.čoyu)

Дээр дурдсанчлан Миньхэ монгол хэлний идэвхгүй сул үгээс үйл үг бүтээх 5.1 -(e)r- [-ø-] болон 5.2 -ra- [-ra-] ~ -ruo- [-ruo-] дагаврын тухайд бол энэхүү хоёр дагаврын илэрхийлэх тусгах, эс тусгах утга нь орчин цагийн монгол хэлнийхээс бараг ялгаагүй, бас эртний монгол хэлний байдлыг нэлээн сайн хадгалж байгаа нь тодорхой байна.

6. Дүгнэлт

Миньхэ монгол хэлний үг бүтээх дагаврын гол гол онцлогийг ерөнхийд нь хэлний “уламжлал” ба “шинэчлэл” гэсэн хоёр талаар дүгнэж болох байна.

6.1 Эртний монгол хэлнээс дамжиж ирсэн хэлний уламжлал

Дээрх жишээнүүдээс үзэхэд Миньхэ монгол хэлний “хам цагийн үг бүтэх ёс” буюу үг бүтээх үндсэн арга нь их хязгаарлагдмал, тийм ч идэвхтэй биш гэж хэлж болно. Ерөнхийд нь хэлэхэд эртний монгол хэлнээс уламжлагдаж ирсэн хэлний уламжлалыг зохих хэмжээгээр сайн хадгалж байна гэж дүгнэж болох байна.

Эртний монгол хэлний, ялангуяа авианы онцлогийг нэлээн сайн хадгалж байх магадлалтай дагаврыг доор хүснэгтээр үзүүлье.

1.1 -buri [-buri] (N-N)	1.10 -ker [-kə] (N-N)
2.4 -ger [-gə] (V-N)	

Миньхэ монгол хэлэнд зарим үгс нэг үгнээс үүссэн үүсмэл үг мэт санагдавч, нарийн ажиглавал “хам цагийн үүсмэл үг” бус, цуваа цагийн хувьд тус тус өөр өөрөөр хувирч хөгжиж ирсний үр дүн гэж үзэж байна.

“Хам цагийн үүсмэл үг” бус жишээг доор дурдъя .

- ① sula- [sula-] (усла-, Mo.usu-la- (N-V)) : suzu [sudzʊ] (ус, Mo.usu)
- ② sangmula- [saŋmula-] (самна-, Mo.sam-na- < *sam-la- (N-V))
: sang [saŋ] (сам, Mo.sam)
- ③ kerli- [kəli-] (“хүсэх, хэрэгтэй байх” хэрэглэ-, Mo.kereg-le- (N-V))
: kheri [qəri] (хэрэг, Mo.kereg)
- ④ arigha- [arica-] (арилга-, Mo.aril-ya- (V-V))
: aruer- [aruə-] (арил-, Mo.aril-)
- ⑤ baguerdu- [baɣuədu-] (“зодолдо-, хэрэлдэ-”) : beghe- [bəgə-] (“зодо-”)
(Хүжү монгол : bagha-ldu- [baɣaldu-] < bagha- [baɣa-])

Хэрвээ дээрх нэр үг *suzu*, *sang*, *kheri* болон үйл үг *aruer-*, *beghe-* гэдгээс шууд үйл үг үүссэн буюу “хам цагийн үүсмэл үг” мөн байсан бол **suzula-*, **sangla-*, **kherili-*, **aruergha-*, **begherdu-* гэмээр үг үүсэх байсан байх. Гэвч тэгээгүй (үнэндээ *sula-*, *sangmula-*, *kerli-*, *arigha-*, *baguerdu-* болсон) нь цуваа цагийн үүднээс үзэхэд эдгээр үгс нь тус тус өөр өөрөөр хувирч хөгжиж ирсэн гэж дүгнэж болмоор байна.

6.2 Миньхэ монгол хэлэнд бий болсон хэлний шинэчлэл

Миньхэ монгол хэлэнд бий болсон хэлний шинэчлэлийг дотор нь ① Эртний монгол хэлнээс уламжлагдаж ирсэн ч Миньхэ монгол хэлэнд зохих хэмжээгээр шинэчлэгдсэн дагавар, ② Зөвхөн Миньхэ монгол хэлний өвөрмөц дагавар гэж хоёр ангилж болох байна.

Үүнийг хүснэгтээр бүдүүвчлэн доор үзүүлбэл:

① Миньхэ монгол хэлний шинэчлэгдсэн дагавар:	
1.11 -ku [-ku] (N-N)	1.13 -si [-si] (N-N)
1.15 -tang [-tan] (N-N)	
3.4 -tu- [-tu-] (N-V)	
4.1 -gha- [-ga-] (V-V)	4.2 -duer- [-duə-] (V-V)
② Миньхэ монгол хэлний өвөрмөц дагавар:	
1.8 -ghulu [-culu] (N-N)	1.9 -her [-xə] (N-N)
2.5 -kuni [-kuni] (V-N)	
3.5 -ke- [-kə-] (N-V)	
4.3 -da- [-da-] (V-V)	

7. Төгсгөл

Миньхэ монгол хэлний үг бүтээх дагаврын энэхүү судалгаа нь тус хэлний үгзүйн судалгааны анхны туршилт болж байгаа бөгөөд ялангуяа монгол төрөл хэл, нутгийн аялгууг судалдаг эрдэмтэн, судлаачдад өчүүхэн ч болов тус дэм болно байх гэж найдаж байна.

Цаашид юуны өмнө Миньхэ монгол хэлний хээрийн судалгаа явуулж, тус хэлний үгийг аль болох олныг түүн цуглууж үгсийн сангаа баяжуулснаар энэхүү судалгаагаа дахин гүнзгий хийх санаатай байна.

Миньхэ монгол хэлийг тал бүрээр судлах нь монгол төрөл хэлний нутгийн аялгууны судалгаанд ихээхэн хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

ХАВСРАЛТ

Тус өгүүлэлд хэрэглэсэн “Миньхэ монгол хэлний латин үсэг” ба “Олон улсын авианы галиг” (IPA)-ийн тохиролцоог доор үзүүлбэл:

1. Эгшиг

1.1 Богино эгшиг

a [a], o [o], u [u ~ y / ε, ʉ, dz-гийн дараа], e [ə], i [i ~ ɪ / s, ts, dz-гийн дараа]

1.2 Хос эгшиг

ai [ai], ei [ei], ao [ao], uo [uo], ou [ou], iu [iu], ie [iə], ue [yə], ua [ua], ia [ia]

1.3 Дараалсан гурван эгшиг

iao [iao], uai [uai]

2. Гийгүүлэгч

b [b], p [p], m [m], w [w], d [d], t [t], z [dz], c [ts], s [s], n [n], l [l], r [r], zh [dz], ch [tʃ], sh[ʃ], j [dʒ], q [tɕ], x [ç], y [j], g [g], k [k], h [x], ng [ŋ], gh [ç], kh [q]

3. Бусад анхаарууштай дуудлага

en [ən ~ m ~ n], er [ə], wu [u], si [si], ci [tsi], zi [dzi], xu [ɕy], qu [tɕy], ju [dʒy]

НОМ ЗҮЙ

Dpal-Idan-bkra-shis, Keith.Slater,et al.

1996 *Language Materials of China's Monguor Minority: Huzhu Mongghul and Minhe Mangghuer*, Sino-Platonic Papers 69, University of Pennsylvania, Philadelphia.

Jiang Genxiong

2018 “Language contact-based research on the evolution and development of the Minhe dialect of Monguor language”, 63-72, *Altai Hakpo* 28, The Altaic Society of Korea, Korea.

Shiotani Shigeki

2019 *Grammar of Mangghuer*, The Research Institute for Languages and Cultures of Asia and Africa, Tokyo.

Шиотани Шигэки

2019 Миньхэ монгор хэлний эгшиг авианы хувьсал хөгжлийг цуваа цагийн үүднээс судлах нь, *Хэл зохиол судлал*, Vol.12(44), 98-106, Улаанбаатар.

Slater, Keith W.

2003a *A Grammar of Mangghuer: A Mongolic language of China's Qinghai-Gansu Sprachbund*, Curzon, London.

Slater, Keith W.

2003b “Mangghuer”, *The Mongolic Languages*, 307-324, Routledge, London and New York.

Тодаева Б.Х

1973 *Монгорский язык : Исследование, тексты, словарь*, НАУКА, Москва.